



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 11 -ны өдөр

Дугаар А/13

Эрдэнэт

Г Гэрийн ажиглалт, хяналтыг эрчимжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Шадар сайдын 2020 оны А/156 дугаар тушаалын 4.6, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/29 дүгээр тушаалын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрийн ажиглалт хяналтад мэргэжил аргазүйн зөвлөмж өгч хамтарч ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын чиг үүрэг, хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Сар шинийн өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрүүдийг томилж голомт бүхий бүс нутгаас ирсэн иргэдийн гэрийн ажиглалтыг эрчимжүүлж ажиллахыг Сум, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Гэрийн ажиглалт, хяналтыг цаашид тасралтгүй чанартай зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангаж үр дүнг тухай бүр мэдээлж ажиллахыг анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан /Б.Хишигжаргал/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/- д даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 02 дүгээр сарын
11-ний өдрийн 1/13 дугаар
тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

№	Нэрс	Албан тушаал	Хугацаа	Хийх ажлын чиглэл	Хамтран ажиллах байгууллага
1	О.Анхбаяр	ЭЧАЭЗХХМ	II.12	1. Автотээврийн хяналтын цэгээр орж ирсэн иргэдийн бүртгэл, тандалт судалгаанд хяналт тавьж асуудлыг шийдвэрлэж ажиллах	МХГ, ОБГ, ЦГ, БаянӨндөр сум
2	М.Ариунэрдэнэ	ХНМэргэжилтэн			
3	Г.Итгэл	Статистикч			
4	Б.Уртнасан	ЯГҮТҮХМэргэжилтэн	II.13	2. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрийн ажиглалтад хамтарсан багаар хяналт хийж илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж ажиллах	
5	Д.Отгондэлгэр	Эдийн засагч			
6	А.Баярхүү	СТҮХМэргэжилтэн			
10	Б.Билгүүн	ХӨТСХМэргэжилтэн			
3	П.Хишгээ	ЭХТҮХМэргэжилтэн	II.14	3. Шаардлагатай тохиолдолд мэдээллийг АОК-ийн Шуурхай шатбын дарга, менежерт шуурхай хүргэж асуудлыг шийдвэрлүүлж ажиллах	
4	Г.Энхжаргал	ХШҮДАХМэргэжилтэн			
5	Х.Оюунэрдэнэ	МТТМХМэргэжилтэн			
6	Н.Мөнгөнцацралт	ХБӨТСХ			
7	Н.Чулуун-Эрдэнэ	Ерөнхий нягтлан			